

МОНГОЛ УЛС – ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ОРЧИН ҮЕИЙН ХАРИЛЦАА

*Л.Хайсандай**

*Х.Мандхай***

Монгол Улс, Холбоот Орос Улсын хооронд 1921 оны 11 дүгээр сарын 5-ны өдөр албан ёсны харилцаа тогтоосон. 1985 онд Зөвлөлт Холбоот Улсад өөрчлөн байгуулалт эхэлж, 1990 онд Монголд ардчилсан хувьсгал гарч, 1991 онд ЗСБНХУ задрах хүртэл Монгол, Зөвлөлтийн харилцаа хоёр системийн сэргэлдөөний хүрээнд ангийн шинж чанар агуулсан, Москвагаас бүх талаар “хараат” шинжтэй байв.

ЗХУ задарсаны дараа ОХУ бий болсноор Монгол, Оросын харилцааны шинэ үе эхэлсэн юм. 1993 онд хоёр улсын хооронд байгуулсан Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай шинэ Гэрээ, 2000 онд гарын үсэг зурсан Улаанбаатарын тунхаглал нь Монгол, Оросын харилцааг өнөөгийн нөхцөл байдалд хөгжүүлэх үндэс суурийг тавьж өгсөн.

Улс төрийн харилцааны салбарт 2000 он хүртэл дээд, өндөр хэмжээний айлчлал зөвхөн манай талаас нэг урсгалтай явж байсан бол 2000 оноос ОХУ-ын Ерөнхийлөгч, Холбооны Зөвлөлийн дарга, Засгийн газрын тэргүүн, Гадаад хэргийн сайд зэрэг дээд, өндөр хэмжээний төлөөлөгчид Монгол Улсад албан ёсоор айлчиллаа.

2005 онд Ерөнхийлөгч Н.Багабанди Москва хотноо болсон Дэлхийн II дайны Ялалтын 60 жилийн ойн арга хэмжээнд оролцож, Оросын удирдлагатай уулзсан. Дараахан нь Астана хотноо, 2006 оны 6 дугаар сард Шанхай хотноо болсон Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын /ШХАБ/ дээд хэмжээний уулзалтын үеэр Ерөнхийлөгч Н.Энхбаяр, ОХУ-ын Ерөнхийлөгч В.В. Путин нар уулзаж, хамтын ажиллагааны асуудлаар санал бодлоо солилцож, харилцаа, хамтын ажиллагааг улам өргөжүүлэхээр тохиролцсон юм.

Монгол Улсын Их Хурлын дарга 2005 оны 1 дүгээр сард ОХУ-д албан ёсны айлчлал хийж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслолд Холбооны Зөвлөлийн дарга С.Миронов тэргүүтэй төлөөлөгчид оролцов. 2006 оны 3 дугаар сард ОХУ-ын Гадаад хэргийн сайд Улаанбаатарт ажлын айлчлал хийж харилцааг ойрын үед урагшлуулан хөгжүүлэх, тухайлбал эдийн засгийн хамтын ажиллагааны өргөн хүрээтэй асуудлаар санал солилцсон болно. 2006 оны 12 дугаар

* Л.Хайсандай - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Sc.D), профессор

** Х.Мандхай - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан

сард Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр ОХУ-д айлчилж, ноён В.В.Путинтай Москвагийн тунхаглалд хамт гарын үсэг зурав.

Энэ айлчлал шинэ зуунд хоёр орны уламжлалт түншлэлийн харилцааг улам өргөжүүлэн хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой болсон гэж үзэж байна.

Монгол Улсын Ерөнхий Сайд С.Баяр ОХУ-ын Засгийн газрын дарга В.А.Зубковын урилгаар 2008 оны 4 дүгээр сарын 10-13-нд ОХУ-д албан ёсны айлчлал хийв. Айлчлалын явцад С.Баяр Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч В.В.Путинд бараалхаж, В.А.Зубковтай хэлэлцээ хийж, Оросын Холбооны Улсын Холбооны Хурлын Төрийн Думын орлогч дарга В.В.Володинтой уулзав.

Итгэлцлийн байдалд болж өнгөрсөн уулзалт, хэлэлцээний явцад Монгол, Оросын харилцааны хөгжил, хэтийн төлөвийн тулгамдсан асуудлуудыг хэлэлцэж, харилцан сонирхсон бүс нутгийн болон олон улсын асуудлаар санал солилцсон байна.

Хоёр Засгийн газрын тэргүүн нар Монгол Улс, Оросын Холбооны Улсын хоорондын найрсаг харилцаа, хамтын ажиллагаа нь 1993 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн гэрээ, 2000 оны 11 дүгээр сарын 14-ны өдрийн Улаанбаатарын Тунхаглал болон 2006 оны 12 дугаар сарын 8-ны Москвагийн Тунхаглалд гарын үсэг зурснаас хойш өнгөрсөн хугацаанд амьдрах чадвартай бөгөөд, хоёр орны ард түмний амин эрх ашигт бүрэн нийцэж байгааг баталлаа гэж онцлон тэмдэглэв.

Хоёр орны Засгийн газрын тэргүүн нар түүхийн явцад бүрэлдсэн уламжлалт найрамдалт, сайн хөршийн харилцаанд үнэнч гэдгээ батлан бүх талын хамтын ажиллагаа, стратегийн түншлэлийг тууштай хөгжүүлж, хоёр талын хамтын ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэхийн төлөө ажиллахаа илэрхийлжээ.

Цэрэг, техникийн хамтын ажиллагаа эдүгээ зогсонги байдлаас аажмаар гарч байна. Монгол Улсад цэрэг, техникийн буцалтгүй тусламж үзүүлэх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрт 2004 онд гарын үсэг зурсан юм..

Энэ дагуу тусгай салбарыг зэвсэглэл, техникээр хангахад зориулж ОХУ-аас 5 сая ам.долларын буцалтгүй тусламж үзүүлсэн байна.

Хуучин ЗСБНХУ нь манай худалдаа, эдийн засгийн гол түнш байсан бол түүнийг залгамлагч ОХУ-ын эзлэх хувийн жин 1990 оноос хойш эрс буурсан юм. 2006 оны байдлаар худалдааны нийт эргэлт 592,9 сая ам.долларт хүрч, импорт 547.8 сая ам.доллар, экспорт 45.1 сая ам.доллар болсон байна. Өнөөдөр хил орчмын бүс нутгийн худалдаа манай хоёр орны нийт худалдааны 70 хувийг эзлэж байна. Өнгөрсөн жилүүдэд Оросын хөрөнгө оруулалт үндсэндээ зогссон. Гэхдээ өнөөдөр Оросын хөрөнгө оруулалттай 300 орчим аж ахуйн нэгж Монголд ажиллаж байгаагийн дотор Оросын талын 100 хувийн хөрөнгө оруулалт бүхий “Зарубежстрой”, “Бурводстрой”, “Золотой Восток-Монголия”, хамтарсан “Инкон”, “Эрдэнэстрой” зэрэг хэд хэдэн томоохон компани үйл ажиллагаа явуулж байна. Монгол, Оросын

хамтын ажиллагааг хөгжүүлэх, шинэ түвшинд гаргах үүднээс 2010 он хүртэлх худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөр боловсруулах, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааны ажлын хэсгийг ЗГХК-ын дэргэд байгуулахаар тохиролцсон.

ОХУ-д төлөх “их өр”-ийн асуудлыг шийдвэрлэсэн явдал манай улсын хувьд түүхэн ач холбогдолтой үйл явдал болсон юм. Ингэснээр хоёр улсын эдийн засгийн хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэх таатай нөхцөл бүрдэх болсон юм.

Хоёр улсын хамтын ажиллагааг зохицуулах механизм хангалттай байна. Тухайлбал, ЗГХК, Бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааны дэд комисс, худалдааг либералчлах ажлын хэсэг, тээвэр болон эрчим хүчний ажлын хэсэг, үл хөдлөх хөрөнгийн ажлын хэсэг зэрэг арав гаруй комисс, хэсэг ажиллаж байна. Эдгээрийн үүрэг, үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх асуудал чухал байна. Соёл, боловсролын солилцоо мөн 1990-ээд оны эхэн болон дунд үед зогсонги байдалд орсон. ОХУ-ын Засгийн газрын шийдвэрээр 1996 оноос эхлэн жил тутам Монголоос 60 хүртэл тооны оюутан, 30 хүртэл аспирант, докторант, мэргэжил дээшлүүлэгч авах болсон бөгөөд 2000 оноос 80 оюутан, 50 аспирант, магистрант, 2003 оноос 200 оюутныг жил болгон авч байна. Энэ салбарын харилцаа мэдэгдэхүйц идэвхжлээ.

Хоёр орны харилцааны эрх зүйн үндсийг цаашид бэхжүүлэх зорилгоор ОХУ-тай 10 гаруй хэлэлцээр шинээр байгуулан ажиллаж байна. ОХУ-тай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах саналыг манай тал тавьж байгаа. ОХУ-ын субъектуудтэй хамтын ажиллагаа хөгжүүлэхэд анхаарч, идэвхижиж байна.

Хилийн бүх боомт “Хилийн боомт болон Монгол, Орос улсын хилийг хялбарчилсан журмаар нэвтрэх тухай” 1994 оны Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу үйл ажиллагаагаа явуулж байна.

Ийнхүү Монгол, Оросын харилцаа олон салбарт нааштай өөрчлөгдөн хөгжиж байгаа боловч шийдвэрлэвэл зохих асуудлууд ч байсаар байна. Тухайлбал: Хоёр талын худалдааг либералчлах, хөнгөвчлөх, өргөжүүлэх, “Монгол-росцветмет”, “УБТЗ” зэрэг Монгол, Оросын хамтарсан томхон үйлдвэрүүдийн үр ашгийг дээшлүүлэх, Оросоос Монголд түлш, эрчим хүчийг найдвартай нийлүүлэх зэрэг болно.

Хоёр улсын иргэд харилцан зорчих нөхцлийг хөнгөвчлөх, визийг үнэ төлбөргүй буюу ихээхэн хөнгөлөлтэйгээр олгох асуудал шийдлээ хүлээж байна.

Хоёр талын консулын ээлжит зөвлөлдөх уулзалт 2005 онд Москвад болж, харилцан визгүй зорчих манай саналыг Оросын тал хүлээн авч болох тухайгаа мэдэгдсэн байгаа. Мөн ОХУ-ын зарим мужид өргөмжит консул томилж ажиллуулахаар ярилцаж, консулын төлөөлөл байгуулах судалгаа хийж байна. Монгол, Оросын хил дээр дэг журмыг сахиулах, малын хулгайгаас сэргийлэх талаар хоёр улсын

хийлийн болон гаалийн байгууллага, тусгай алба уялдуулан зохицуулсан ажиллагааг хамтран явуулах асуудлыг хэлэлцэж хамтаар шийдвэрлэж байна. Тийнхүү хоёр хөрштэйгээ тэнцвэртэй харилцах тухай манай гадаад бодлогын үзэл баримтлалын зорилт улс төрийн утгаараа хэрэгжиж байх боломж нөхцөл бүрэн бүрэлдсэн гэж болно.

Харилцан ашигтай хамтын ажиллагаа нь улс төр, эдийн засаг худалдаа-бизнес, боловсрол, соёл, шинжлэх ухаан, хүмүүнлэг, байгаль орчин, батлан хамгаалах зэрэг бүхий л салбарыг хамран амжилттай хөгжиж байна. Төр, Засгийн бүх шатны байгууллагууд, яам газар, агентлагууд, хил орчмын бүс нутгийн муж, хязгаар, бүгд найрамдах улсууд, аймаг, хотууд, төрийн бус, олон нийтийн байгууллагуудын шууд харилцаа, хамтын ажиллагаа идэвхиж байгаа байдал илт мэдрэгдэх боллоо.

Энэ бүхнийг дүгнэж өгүүлвээс:

1. Монгол Улсын хөгжлийн гадаад орчин, хүчин зүйлд ойрын хөрш –ОХУ, БНХАУ маш чухал байр суурь эзэлдэг билээ. Энэ хоёр гүрний хооронд стратегийн түншлэлийн харилцаа хөгжиж, харилцан итгэлцэл нэмэгдэж байгаа нь Монгол Улсын хөгжил дэвшил, аюулгүй байдалд таатай нөхцөл бүрдүүлж байна.

2. Манай хоёр хөршийн болон Зүүн Хойт Ази, Төв Азийн гол гол орнуудын хоорондын харилцааны төлөв байдал, хоёр Солонгосын өөр хоорондын харилцаа нь манай гадаад орчныг тодорхойлох чухал хүчин зүйл бас болдог билээ. Мөн гадаад худалдааны хүчин зүйл, тухйлбал зэс, алт, ноолуур, газрын тосны дэлхийн зах зээл дээрх үнэ ханш зэрэг нь өнөө ч, цаашдаа ч Монголын хөгжлийн гадаад орчинд нөлөөлөх чухал хүчин зүйл хэвээр байна, байх ч болно.

3. Ази-Номхон далайн бүс нутагт үүсч төлөвшиж буй олон талт яриа хэлэлцээний бүтцүүд нь бүс нутгийн түүний дотор манай улсын аюулгүй байдал, гадаад хамтын ажиллагааны тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд ихээхэн ач холбогдолтой юм.

Ашигласан материал:

1. Монгол Улс, ОХУ-ын харилцааны баримт бичгийн эмхэтгэл. УБ. 2006
2. Монгол-Оросын харилцаа: бүсчилсэн хөгжлийн бодлого, хамтын ажиллагаа. УБ. 2005
3. “Зууны мэдээ”. 2007.12.10, №294
4. “Өнөөдөр”. 2007.09.24, №223
5. “Үнэн”, (Монгол-Оросын хамтарсан албан мэдээ) 2008.04.15, №072